



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.3} дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Худалдан борлуулах аймаг, нийслэлийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ё.Жаргалсайхан/-т даалгасугай.

3. Дуудлага худалдааг зохион байгуулахдаа сонирхогчдын тэгш оролцоог хангах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх, үр дүнг сурталчлах, ил тод байдлыг хангаж ажиллахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

САЙД  Л.ХАЛТАР



080000608

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2022 оны А/222 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААРЫН ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын хүрээнд тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдааг зохион байгуулахад оршино.

1.2. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулахдаа Автотээврийн тухай хууль, Иргэний хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох журам, стандартыг мөрдлөг болгоно.

1.3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д заасан сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах замаар дуудлага худалдаагаар худалдан борлуулна.

Хоёр. Улсын дугаарын дуудлага худалдааг зохион байгуулах

2.1. Дуудлага худалдаанд оролцогчид үнийн саналаа ээлж дараалан өсгөх бөгөөд дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон оролцогч этгээд байна.

2.2. Дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй, нэг этгээд оролцсон, эсхүл оролцогчдоос зөвхөн нэг нь үнийн санал өгсөн бол тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцно.

2.3. Дуудлага худалдаанд бүртгүүлсэн этгээд дуудлага худалдаанд ороогүй бол түүнийг дуудлага худалдаанд оролцохоос татгалзсанд тооцож, энэ тухай дуудлага худалдааны тэмдэглэлд тусгана.

2.4. Дуудлага худалдаанд оролцогч үнийн саналаа өгснөөс хойш 2 минутын дотор бусад оролцогч өмнө өгсөн оролцогчийн үнийн саналаас дээш үнийн санал өгөөгүй тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаар худалдагдсанд тооцож дуудлага худалдаа хаагдана.

2.5. Энэхүү журмын 4.8-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд дуудлага худалдааны ялагчид төлсөн төлбөрийг буцаан олгохдоо дуудлага худалдааны дэнчинг хасч шилжүүлнэ.

2.6. Цахим дуудлага худалдааны эхлэх, дуусах цагийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын цагаар тооцно.

2.7. Цахим дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг цахим дуудлага худалдаа явагдахаас 3 хоногийн өмнөөс хүлээн авч эхлэн дуудлага худалдаа явагдах өдрийн өмнөх өдрийн 23 цаг 00 минутад зогсоож, бүртгэлийг хаана.

2.8. Дуудлага худалдаанд оролцогч үнэ өсгөх доод хэмжээ нь 50,000 /тавин мянга/ төгрөг, дээд хэмжээ 1,000.000 /нэг сая/ төгрөг байна.

2.9. Дуудлага худалдааг зохион байгуулагч нь дуудлага худалдааны ялагчтай тодорхой нөхцөл бүхий Улсын бүртгэлийн дугаар олгох гэрээг байгуулна.

2.10. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаанаас төвлөрүүлсэн орлогоос дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд 10 хувийг суутган тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай санд төвлөрүүлнэ.

2.11. Дуудлага худалдаанд оролцон ялагч болсон иргэн тухайн дугаарыг холбогдох журмын хүрээнд бүртгүүлэн авсан тохиолдолд дуудлага худалдааны дугаарын төлбөрийг буцаан олгохгүй.

Гурав. Дуудлага худалдаа зохион байгуулагч байгууллагын эрх үүрэг


3.1. Улсын бүртгэлийн дугаарын үнэ хаялцуулах үйл ажиллагааг тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага бусад байгууллагатай хамтран энэхүү журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

3.2. Улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулагч байгууллага нь дуудлага худалдааны программын хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал болон хөгжүүлэлтийг бүрэн хангаж ажиллана.

3.3. Улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулагч байгууллага нь дуудлага худалдааны дэнчинг хүлээн авах, буцаан олгох, мөн энэ журмын 4.8-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд ялагч болсон иргэнд дуудлага худалдаагаар авсан улсын бүртгэлийн дугаарын төлбөрийг буцаан олгох, дуудлага худалдаагаар олгосон улсын бүртгэлийн дугаарын үнийг дансанд төвлөрүүлэн, холбогдох зардлыг суутган тооцож тусгай санд шилжүүлэх зэрэг санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллана.

3.4. Улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулагч байгууллага нь худалдан борлуулах жагсаалтад орсон улсын бүртгэлийн дугаарыг эрэмбэлэн цахим системд тухай бүр оруулна.

3.5. Улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулагч байгууллага нь дуудлага худалдааны зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.



3.6. Дуудлага худалдаа зохион байгуулагч байгууллага нь хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх.

Дөрөв. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаанд оролцогчийн эрх үүрэг

4.1. Дуудлага худалдаанд оролцогч нь өөрийн оршин суух засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу улсын бүртгэлийн дугаарыг сонгон оролцоно.

4.2. Дуудлага худалдаанд оролцохыг хүсэгч нь цахим системд бүртгүүлж, гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөн дэнчин төлснөөр оролцох эрх үүснэ.

4.3. Дуудлага худалдаанд Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн бүгд дуудлага худалдаанд оролцох эрхтэй.

4.4. Дуудлага худалдааны зар мэдээлэлд заасан цаг хугацаанд оролцогч нь дуудлага худалдааны цахим системд нэвтэрсэн байна.

4.5. Цахим систем дуудлага худалдаа эхэлснийг мэдэгдэж хугацаа тоолж эхэлснээр дуудлага худалдаа албан ёсоор эхэлсэнд тооцно.

4.6. Тухайн дуудлага худалдаанд ялснаар оролцогч зохион байгуулагч байгууллагатай энэхүү журмын 2.9-д заасны дагуу гэрээ байгуулна.

4.7. Дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарын төлбөрийг тухайн дуудлага худалдаа зохион байгуулснаас хойш 24 цагийн дотор зохион байгуулагч байгууллагын дансанд төлж гэрээ байгуулна.

4.8. Худалдан авагч нь энэхүү гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгүүлэх бөгөөд хэрвээ заасан хугацаанд бүртгэлийн санд бүртгүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлан тухайн улсын бүртгэлийн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулна.


Тав. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааны дэнчин

5.1 Энэхүү журмын хавсралтад заасны дагуу тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааны дэнчингийн хэмжээг тогтооно.

5.2. Тухайн дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор багтаан дэнчин төлсөн дансанд буцаан олгоно.

5.3. Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн худалдан авах улсын бүртгэлийн дугаарын үнийн төлбөрт дэнчинг оруулан тооцно.

5.4. Энэхүү журмын 4.7-д заасан хугацаанд улсын бүртгэлийн дугаарын үнэ төлөгдөөгүй, 4.8-д заасан хугацаанд улсын бүртгэлийн санд бүртгүүлээгүй тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулах бөгөөд дэнчинг буцаан олгохгүй.



Зургаа. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг дахин явуулах

6.1. Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

6.1.1. Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарын үнийг журмын 4.7-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй, төлөхийг зөвшөөрөхгүй эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд;

6.1.2. Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг журмын 4.8-д заасан хугацаанд бүртгэлийн санд бүртгүүлээгүй;

6.1.3. Дуудлага худалдаа явагдаагүй эсвэл явуулах нөхцөл бүрдээгүй;

6.1.4. Дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй, нэг этгээд оролцсон, эсхүл оролцогчдоос зөвхөн нэг нь үнийн санал өгч хүчингүй болсон дуудлага худалдаа;

6.1.5. Хууль зөрчин хууль бус дуудлага худалдаа явуулсныг шүүхээр тогтоосон;

6.1.6. Хуульд заасан бусад тохиолдолд

6.2. Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг бүртгэлийн байгууллага буюу зохион байгуулагч байгууллага гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 7-оос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

6.3. Дуудлага худалдааг дахин явуулахдаа энэ журмыг мөрдөнө.

Долоо. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааны ялагчид худалдан авсан улсын бүртгэлийн дугаарыг олгох

7.1 Дуудлага худалдаанд ялсан оролцогчтой байгуулах гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:


7.1.1. Худалдан авсан улсын бүртгэлийн дугаар;

7.1.2. Дуудлага худалдааны ялагч нь иргэн бол овог нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг;

7.1.3. Дуудлага худалдааны ялагч нь хуулийн этгээд бол байгууллагын нэр, регистр;

7.1.4. Үнэ төлсөн баримт;

7.1.5. Улсын бүртгэлийн дугаарыг захиалах хугацаа;




7.2. Дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээг үндэслэн “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д заасны дагуу тээврийн хэрэгслийн улсын дугаарыг олгож бүртгэл хөтөлнө.

Найм. Бусад

8.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан эсхүл програм хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдсоноос цахим дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцож, дээрх нөхцөл байдал хэвийн болсноос хойш ажлын 5 хонгийн дотор дахин зохион байгуулна.

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2022 оны /12/ дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт




ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААРЫН ЖАГСААЛТ

/дуудлага худалдаагаар худалдан борлуулах нийслэл/

Улаанбаатар хотын /731/

№	000A /9/ A000 /9/ AAAA /9/ OAAA /9/ 0A00 /9/	00A0 /9/, 00AA /9/, 00AB /72/		ABAB /90/		ABBA /90/		AABB /81/ AAA0 /9/	
1	0001	0010	0045	0101	5050	0110	5005	1100	6600
2	0002	0020	0046	0202	5151	0220	5115	1122	6611
3	0003	0030	0047	0303	5252	0330	5225	1133	6622
4	0004	0040	0048	0404	5353	0440	5335	1144	6633
5	0005	0050	0049	0505	5454	0550	5445	1155	6644
6	0006	0060	0051	0606	5656	0660	5665	1166	6655
7	0007	0070	0052	0707	5757	0770	5775	1177	6677
8	0008	0080	0053	0808	5858	0880	5885	1188	6688
9	0009	0090	0054	0909	5959	0990	5995	1199	6699
10	1111	0011	0056	1010	6060	1001	6006	2200	7700
11	2222	0022	0057	1212	6161	1221	6116	2211	7711
12	3333	0033	0058	1313	6262	1331	6226	2233	7722
13	4444	0044	0059	1414	6363	1441	6336	2244	7733
14	5555	0055	0061	1515	6464	1551	6446	2255	7744
15	6666	0066	0062	1616	6565	1661	6556	2266	7755
16	7777	0077	0063	1717	6767	1771	6776	2277	7766
17	8888	0088	0064	1818	6868	1881	6886	2288	7788
18	9999	0099	0065	1919	6969	1991	6996	2299	7799
19	0111	0012	0067	2020	7070	2002	7007	3300	8800
20	0222	0013	0068	2121	7171	2112	7117	3311	8811
21	0333	0014	0069	2323	7272	2332	7227	3322	8822
22	0444	0015	0071	2424	7373	2442	7337	3344	8833
23	0555	0016	0072	2525	7474	2552	7447	3355	8844
24	0666	0017	0073	2626	7575	2662	7557	3366	8855
25	0777	0018	0074	2727	7676	2772	7667	3377	8866
26	0888	0019	0075	2828	7878	2882	7887	3388	8877
27	0999	0021	0076	2929	7979	2992	7997	3399	8899
28	1000	0023	0078	3030	8080	3003	8008	4400	9900
29	2000	0024	0079	3131	8181	3113	8118	4411	9911
30	3000	0025	0081	3232	8282	3223	8228	4422	9922
31	4000	0026	0082	3434	8383	3443	8338	4433	9933

32	5000	0027	0083	3535	8484	3553	8448	4455	9944
33	6000	0028	0084	3636	8585	3663	8558	4466	9955
34	7000	0029	0085	3737	8686	3773	8668	4477	9966
35	8000	0031	0086	3838	8787	3883	8778	4488	9977
36	9000	0032	0087	3939	8989	3993	8998	4499	9988
37	0100	0034	0089	4040	9090	4004	9009	5500	1110
38	0200	0035	0091	4141	9191	4114	9119	5511	2220
39	0300	0036	0092	4242	9292	4224	9229	5522	3330
40	0400	0037	0093	4343	9393	4334	9339	5533	4440
41	0500	0038	0094	4545	9494	4554	9449	5544	5550
42	0600	0039	0095	4646	9595	4664	9559	5566	6660
43	0700	0041	0096	4747	9696	4774	9669	5577	7770
44	0800	0042	0097	4848	9797	4884	9779	5588	8880
45	0900	0043	0098	4949	9898	4994	9889	5599	9990
3 ижил цифртэй 306 дугаар									
№	1-н цифр 3 удаа орсон	2-н цифр 3 удаа орсон	3-н цифр 3 удаа орсон	4-н цифр 3 удаа орсон	5-н цифр 3 удаа орсон	6-н цифр 3 удаа орсон	7-н цифр 3 удаа орсон	8-н цифр 3 удаа орсон	9-н цифр 3 удаа орсон
1	34	34	34	34	34	34	34	34	34
2	1011	2022	3033	4044	5055	6066	7077	8088	9099
3	1101	2111	3111	4111	5111	6111	7111	8111	9111
4	1112	2122	3133	4144	5155	6166	7177	8188	9199
5	1113	2202	3222	4222	5222	6222	7222	8222	9222
6	1114	2212	3233	4244	5255	6266	7277	8288	9299
7	1115	2221	3303	4333	5333	6333	7333	8333	9333
8	1116	2223	3313	4344	5355	6366	7377	8388	9399
9	1117	2224	3323	4404	5444	6444	7444	8444	9444
10	1118	2225	3331	4414	5455	6466	7477	8488	9499
11	1119	2226	3332	4424	5505	6555	7555	8555	9555
12	1121	2227	3334	4434	5515	6566	7577	8588	9599
13	1131	2228	3335	4441	5525	6606	7666	8666	9666
14	1141	2229	3336	4442	5535	6616	7677	8688	9699
15	1151	2232	3337	4443	5545	6626	7707	8777	9777
16	1161	2242	3338	4445	5551	6636	7717	8788	9799
17	1171	2252	3339	4446	5552	6646	7727	8808	9888
18	1181	2262	3343	4447	5553	6656	7737	8818	9899
19	1191	2272	3353	4448	5554	6661	7747	8828	9909
20	1211	2282	3363	4449	5556	6662	7757	8838	9919
21	1222	2292	3373	4454	5557	6663	7767	8848	9929
22	1311	2322	3383	4464	5558	6664	7771	8858	9939
22	1333	2333	3393	4474	5559	6665	7772	8868	9949
23	1411	2422	3433	4484	5565	6667	7773	8878	9959
24	1444	2444	3444	4494	5575	6668	7774	8881	9969
25	1511	2522	3533	4544	5585	6669	7775	8882	9979
26	1555	2555	3555	4555	5595	6676	7776	8883	9989
27	1611	2622	3633	4644	5655	6686	7778	8884	9991
28	1666	2666	3666	4666	5666	6696	7779	8885	9992




29	1711	2722	3733	4744	5755	6766	7787	8886	9993
30	1777	2777	3777	4777	5777	6777	7797	8887	9994
31	1811	2822	3833	4844	5855	6866	7877	8889	9995
32	1888	2888	3888	4888	5888	6888	7888	8898	9996
33	1911	2922	3933	4944	5955	6966	7977	8988	9997
34	1999	2999	3999	4999	5999	6999	7999	8999	9998
Бусад /20/									
35	0123	4567	6789	0120	0250	0450	0570	0203	0405
36	2345	5678	0105	0150	0350	0470	0102	0304	0506
37	0708	0809							


**ХУДАЛДАН БОРЛУУЛАХ 21 АЙМГИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААРЫН ЖАГСААЛТ /153/**

№	AAAA/9/	000A/9/	0AAA/9/	00A0/9/	AABB/81/				
					1100	2200	3300	4400	5500
1	1111	0001	0111	0010	1100	2200	3300	4400	5500
2	2222	0002	0222	0020	1122	2211	3311	4411	5511
3	3333	0003	0333	0030	1133	2233	3322	4422	5522
4	4444	0004	0444	0040	1144	2244	3344	4433	5533
5	5555	0005	0555	0050	1155	2255	3355	4455	5544
6	6666	0006	0666	0060	1166	2266	3366	4466	5566
7	7777	0007	0777	0070	1177	2277	3377	4477	5577
8	8888	0008	0888	0080	1188	2288	3388	4488	5588
9	9999	0009	0999	0090	1199	2299	3399	4499	5599
10	A000 /9/	00AA/9/	0A00/9/	A0A0/9/	6600	7700	8800	9900	
11	1000	0011	0100	1010	6611	7711	8811	9911	
12	2000	0022	0200	2020	6622	7722	8822	9922	
13	3000	0033	0300	3030	6633	7733	8833	9933	
14	4000	0044	0400	4040	6644	7744	8844	9944	
15	5000	0055	0500	5050	6655	7755	8855	9955	
16	6000	0066	0600	6060	6677	7766	8866	9966	
17	7000	0077	0700	7070	6688	7788	8877	9977	
18	8000	0088	0800	8080	6699	7799	8899	9988	
19	9000	0099	0900	9090					

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны
 07 дугаар сарын 06-ны өдрийн 11/27 дугаар
 тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн
 улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг
 зохион байгуулах журам"-ын хавсралт



**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
 ДУГААРЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
 ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Сери	Дэнчингийн хэмжээ /төгрөг /
1	000A / 9 дугаар /	2 сая
2	AAAA / 9 дугаар /	
3	00A0 / 9 дугаар /	500 000
4	0AAA / 9 дугаар /	
5	A000 / 9 дугаар /	
6	00AA / 9 дугаар /	
7	0A00 / 9 дугаар /	
8	00AB / 72 дугаар /	100 000
9	ABAB / 90 дугаар /	
10	ABBA /90 дугаар/	
11	AABB / 81 дугаар /	
12	AAA0 / 9 дугаар / /20/	
13	AAAB 3 ижил цифр /306 дугаар/	
14	Бусад	
15	Орон нутгийн сери бүгд	100 000

---oOo---